



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 04 сарын 16 өдөр

Дугаар А/111

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дэхь хэсэг, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2026 оны 03 дугаар Хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад "Их нүүдэл" сургалтын удирдлагын системтэй хамтарсан сургалтыг зохион байгуулсантай холбогдон гарсан зардал болох 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга (Д.Буянхишиг)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

